



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг сайжруулах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 11¹.1.2, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 4.1.2-т заасныг тус тус үндэслэн Цөмийн энергийн комиссоос ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгасугай:

- Монгол Улсын Засгийн газар, Цөмийн энергийн комиссоос 2015-2021 онд батлан гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын холбогдох заалтыг харгалзах хяналтын хуудсуудад тусгах, норм, журам, дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан ОУАЭА-ийн төсөл хөтөлбөрийн хүрээнд хүлээн авсан лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангуулж, радиохимийн лабораторийг ашиглалтад оруулах.

2. Дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Ажлын албанд даалгасугай:

- ОУАЭА-тай хамтран идэвхгүй детектор ашиглан радоны хуримтлалыг тодорхойлох төслийг хэрэгжүүлэх;
- Эмчилгээ, оношилгооны зориулалттай аппарат төхөөрөмжийн чанарын хяналтын багажаар Мэргэжлийн хяналтын байгууллагыг хангах асуудлыг ОУАЭА болон бусад санхүүжилтийн эх үүсвэр шийдэх бололцоотой байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- Дулааны цахилгаан станцын хаягдал үнсний цацрагийн үзүүлэлтийг тодорхойлж, барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах боломжийг холбогдох байгууллагуудтай хамтран судлах ажлыг зохион байгуулах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-д даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
КОМИССЫН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

01 0015